



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: mmm.aiьЙ.тп Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: bo1ьсь@aiьН.до^.тп Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас:315558 Цахим хаяг: 1и^8ыпбауагкь@aiьН.до^.тп
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: o1допбауагба@aiьН.до^.тп
	Аудитор: Э.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: ипбагтаае@aiьН.до^.тп

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СА	Санхүүгийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ дэх
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН ЗАСАГДАРГА,
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
А.СҮХБОЛД ТАНАА

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо.
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: иб@аи<1й.доу.тп, Вэбсайт: үүүүүү.айдй.тл

танай-ны №-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дүүргийн Засаг даргын захирамжаар 2024 оны орлогын төлөвлөгөөг биелүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх чиглэлээр Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг томилон, фокус бүлгийн уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласнаар дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг 193.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дүүргийн Засаг даргад тайлант онд 8,4226.6 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд түүнд 2 удаа тодотгол хийж 21.6 хувиар нэмэгдүүлэн нийт 10,748.0 сая төгрөг болсон байна. Үйл ажиллагаандаа 9,639.6 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 30.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-ын эдийн засгийн зорилтот түвшнийг алдагдалтай ажиллахаар баталсанд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 зорилт, 18 зорилгын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТО



эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ЭРДЭНЭЖАРГАЛ

Б<сЫд'202503 15.0к@2абад.0агда <к><

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,462,730.10	3,567,458.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,315,191.80	2,523,947.10
33	АВЛАГА	40,097.90	65,612.50
34	УРЬДЧИЛГАА	2,606.40	1,243.90
35	БАРАА МАТЕРИАЛ	817,245.60	568,012.20
36	НӨӨЦИЙН БАРАА	287,588.40	349,288.40
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0	59,354.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,606,953.00	14,629,885.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,606,953.00	14,629,885.00
39200	Биет хөрөнгө	14,153,789.70	14,178,874.90
39300	Биет бус хөрөнгө	453,163.30	451,010.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 111=1+11	17,069,683.10	18,197,343.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	121,380.20	241,178.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	121,380.20	121,267.60
41300	Өглөг	118,396.00	119,868.70
41400	Урьдчилж орсон орлого	2,984.20	1,399.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	119,911.20
42200	Урт хугацаат зээл	0	119,911.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,948,302.90	17,956,164.70
51	Засгийн газрын хувь оролцоо	16,948,302.90	17,956,164.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,115,911.00	2,114,849.20
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,095,543.40	3,604,082.80
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	356,188.90	356,188.90
51200	Хуримтлагдсан үр дүн	7,783,852.10	8,225,132.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,596,807.50	3,655,911.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН ^1=М+^	17,069,683.10	18,197,343.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,340,643.00	13,320,689.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,413,714.20	2,220,899.20
110	Орлогын албан татвар	1,205,746.00	1,799,314.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,205,746.00	1,799,314.40
113	Хөрөнгийн албан татвар	59,716.60	200,692.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	148,251.60	220,892.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,450,461.80	2,890,620.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,073,544.00	2,323,143.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	376,917.70	567,476.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,476,467.10	8,209,170.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,049,332.60	11,684,958.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,049,332.60	11,684,958.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,883,877.70	10,703,014.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,303,316.90	3,206,515.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	281,351.00	387,786.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	434,537.70	466,540.60
2104	Хангамж, бараа материалын зардал	109,657.40	134,505.60
2105	Нормативт зардал	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,761.30	84,375.70
2107	Томилолт, зочны зардал	33,938.80	34,022.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,143,543.80	4,104,285.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,529,770.80	2,284,981.50
212	ТАТААС	2,058,819.50	661,606.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,635.40	320,337.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(I)-(II)	1,291,310.40	1,635,731.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	137,011.00	1,202,973.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН №)=(ШЖМ)-М	1,154,299.40	432,758.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,066,704.90	-	15,066,704.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,128,215.20	-	4,128,215.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,194,920.00	-	19,194,920.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(55,444.90)	-	(55,444.90)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	(3,345,471.60)	-	(3,345,471.60)
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,154,299.40	-	1,154,299.40
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,948,302.90	-	16,948,302.90
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,948,302.90	-	16,948,302.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,056.20	-	7,056.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,955,359.10	-	16,955,359.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	59,508.30	-	59,508.30
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	508,539.40	-	508,539.40
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	432,758.00	-	432,758.00
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,956,164.70	-	17,956,164.70

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,741,954.8	12,403,578.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,413,714.2	2,220,899.2
110	Орлогын албан татвар	1,205,746.0	1,799,314.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,205,746.0	1,799,314.4
113	Хөрөнгийн албан татвар	59,716.6	200,692.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	148,251.6	220,892.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	38,135.4	112,081.6
1181	Газрын төлбөр	103,779.7	101,011.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,336.5	7,798.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,851,773.6	1,974,503.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,474,855.8	1,407,027.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	376,917.7	567,476.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,476,467.1	8,208,176.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,746,424.1	9,926,241.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,746,424.1	9,926,241.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,290,989.4	9,572,739.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,528,772.7	5,087,485.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	628,009.6	927,440.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	733,020.6	833,990.8
2104	Хангамж, бараа материалын зардал	996,228.4	1,160,599.3
2105	Нормативт зардал	350.0	438.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,378.1	90,825.0
2107	Томилолт, зочны зардал	21,938.8	41,411.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	752,539.0	856,993.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	569,752.1	573,555.2
212	ТАТААС	-	28,970.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	455,434.8	324,532.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(I)-(II)	995,530.7	2,477,337.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	431,356.8	1,268,582.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	431,356.8	1,268,582.2
2200	Дотоод эх үүсвэрээр	431,356.8	1,268,582.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y1)=(1Y)-(Y)	(431,356.8)	(1,268,582.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	564,173.8	1,208,755.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	751,018.0	1,315,191.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,315,191.8	2,523,947.1

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ЗӨРҮҮ	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,747,952.4	9,639,574.5	1,108,377.9	89.7
УРСГАЛ ЗАРДАЛ	9,095,604.1	8,475,082.3	620,521.8	93.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,521,672.2	4,950,295.6	571,376.6	89.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,487,418.4	3,196,977.1	290,441.3	91.7
Үндсэн цалин	1,842,582.7	1,765,036.3	77,546.4	95.8
Нэмэгдэл	769,369.8	636,206.0	133,163.8	82.7
Унаа хоолны хөнгөлөлт	495,097.1	421,932.9	73,164.2	85.2
Урамшуулал	299,368.8	292,801.8	6,567.0	97.8
Гэрээт ажлын хөлс	81,000.0	81,000.0	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	437,554.6	390,252.0	47,302.6	89.2
Тэтгэврийн даатгал	298,318.6	266,390.7	31,927.9	89.3
Тэтгэмжийн даатгал	34,808.6	31,049.2	3,759.4	89.2
ҮОМШӨ-ний даатгал	18,719.3	17,059.0	1,660.3	91.1
Ажилгүйдлийн даатгал	16,090.0	13,643.6	2,446.4	84.8
Эрүүл мэндийн даатгал	69,618.1	62,109.5	7,508.6	89.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	688,340.6	466,540.6	221,800.0	67.8
Гэрэл, цахилгаан	94,055.8	51,569.5	42,486.3	54.8
Түлш, халаалт	511,861.5	373,091.7	138,769.8	72.9
Цэвэр, бохир ус	64,331.3	38,650.2	25,681.1	60.1
Байрны түрээс	18,092.0	3,229.2	14,862.8	17.8
Хангамж, бараа материалын зардал	108,701.1	105,470.3	3,230.8	97.0
Бичигхэрэг	29,182.0	29,088.9	93.1	99.7
Тээвэр, шатахуун	20,694.5	20,910.0	(215.5)	101.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,066.6	13,781.0	3,285.6	80.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,140.0	6,097.4	42.6	99.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,618.0	35,593.0	25.0	99.9
Нормативт зардал	438.0	438.0	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	438.0	438.0	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	144,996.4	144,811.3	185.1	99.9
Багаж, техник, хэрэгсэл	25,900.0	25,900.0	-	100.0
Тавилга	17,000.0	16,899.6	100.4	99.4
Урсгал засвар	102,096.4	102,011.7	84.7	99.9
Томилолт, зочны зардал	42,731.0	41,411.0	1,320.0	96.9
Гадаад албан томилолт	14,000.0	14,000.0	-	100.0
Дотоод албан томилолт	28,731.0	27,411.0	1,320.0	95.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,888.0	231,900.9	987.1	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	218,406.5	218,345.7	60.8	100.0
Даатгалын үйлчилгээ	1,369.1	1,122.6	246.5	82.0
Тээврийн хэрэгслийн татвар	580.4	526.3	54.1	90.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	599.0	575.0	24.0	96.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,063.0	3,763.0	300.0	92.6
Газрын төлбөр	6,870.0	6,752.3	117.7	98.3

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000.0	816.0	184.0	81.6
Бараа үйлчилгээний бусад зардал	378,604.1	372,494.3	6,109.8	98.4
Бараа үйлчилгээний бусад зардал	369,601.6	363,593.6	6,008.0	98.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,002.5	8,900.7	101.8	98.9
ТАТААС	3,215,547.2	3,200,254.6	15,292.6	99.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,215,547.2	3,200,254.6	15,292.6	99.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,215,547.2	3,200,254.6	15,292.6	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	358,384.7	324,532.1	33,852.6	90.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	17,000.0	17,000.0	-	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,000.0	17,000.0	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	341,384.7	307,532.1	33,852.6	90.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,285.0	2,700.0	21,585.0	11.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,000.0	3,000.0	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,916.9	76,966.2	1,950.7	97.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	197,042.8	187,032.9	10,009.9	94.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,140.0	37,833.0	307.0	99.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,652,348.3	1,164,492.2	487,856.1	70.5
Их засвар	628,111.1	587,327.3	40,783.8	93.5
Тоног төхөөрөмж	12,525.0	11,850.0	675.0	94.6
Бусад хөрөнгө	1,011,712.2	565,314.9	446,397.3	55.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,747,952.4	9,613,173.6	1,134,778.8	89.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	592,570.0	567,476.4	25,093.6	95.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	592,570.0	567,476.4	25,093.6	95.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,042,239.8	9,016,787.8	25,452.0	99.7
Орон нутгийн төсвөөс	9,042,239.8	9,016,787.8	25,452.0	99.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,113,142.6	28,909.4	1,084,233.2	2.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,536.3	28,909.4	(3,373.1)	113.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,087,606.3	-	1,087,606.3	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	60,354.0	(60,354.0)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,953.1	(33,953.1)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	246	246	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6	-	100.0
Төсвийн байгууллага	6	6	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	120	120	-	100.0
Удирдах ажилтан	13	13	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	72	72	-	100.0
Үйлчлэх ажилтан	29	29	-	100.0
Гэрээт ажилтан	6	6	-	100.0

ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	120	120	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч	42	42	-	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4	-	100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	11	11	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	47	47	-	100.0
Гэрээт ажилтан	6	6	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	10	10	-	100.0

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	972,484.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	972,484.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,719.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,719.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,791.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	173,489.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,301.8
212	ТАТААС	632,636.7
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	632,636.7
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	632,636.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,338.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,338.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,338.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	972,484.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	972,484.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,490.0
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,231.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	826,680.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,082.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багахангай дүүрэг нь эрхэм зорилгоо “Төрийн захиргаа, иргэн, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн, үнэн зөв, ил тод мэдээллийн эх сурвалж ашиглан, дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчилдэг, өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг

үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, дүүргийн удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах 6 бодлого, 25 зорилтыг хэрэгжүүлж ажиллана гэж тодорхойлжээ. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого /2 зорилт, 11 арга хэмжээ/;
- Хүний хөгжлийн бодлого /8 зорилт, 45 арга хэмжээ/;
- Эдийн засгийн бодлого /4 зорилт, 22 арга хэмжээ/;
- Засаглалын бодлого /3 зорилт, 21 арга хэмжээ/;
- Ногоон хөгжлийн бодлого /2 зорилт, 7 арга хэмжээ/;
- Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого /6 зорилт, 33 арга хэмжээ/.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Багахангай дүүргийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/;
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай”.

Нийслэлийн Багахангай дүүргийн Дотоод аудитын алба нь Дотоод аудитын хорооны баталсан 2024 оны аудит, хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу давхардсан тоогоор 64 байгууллагад 16 дотоод аудит, хяналт шалгалт, сэдвийн 2 аудит, захиалгат 8 хяналт шалгалт, нийцлийн 4 аудит, гүйцэтгэлийн 4 аудит, зөвлөн туслах 14 ажил гүйцэтгэхээр төвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Тайлант онд нийт 44,700.0 сая төгрөгийн 10 зөрчил илрүүлэн зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 90.3 хувьтай байна гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус дүүргийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Харин “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим бүлэг болох үндсэн хөрөнгө, эздийн өмч, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр зэргийг СТОУС болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын өөрчлөлт, шинэчлэлтэд нийцүүлж шинэчлэн боловсруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,127,660.4 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,315,191.8	2,523,947.1	1,208,755.3
Авлага	40,097.9	65,612.5	25,514.6
Урьдчилгаа	2,606.4	1,243.9	(1,362.5)
Бараа материал	817,245.6	568,012.2	(249,233.4)
Нөөцийн бараа	287,588.4	349,288.4	61,700.0
Бусад эргэлтийн хөрөнгө	-	59,354.3	59,354.3
Үндсэн хөрөнгө	14,606,953.0	14,629,885.0	22,932.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,069,683.1	18,197,343.5	1,127,660.4
Өр төлбөр	121,380.2	241,178.8	119,798.7
Засгийн газрын хувь оролцоо	16,948,302.9	17,956,164.7	1,007,861.8
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	17,069,683.1	18,197,343.5	1,127,660.4

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,523,947.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,208,755.3 мянган төгрөгөөр буюу 91.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	358.5	-	(358.5)
Төгрөг	358.5	-	(358.5)
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,309,475.2	2,518,943.9	1,209,468.7
Төгрөг	1,309,475.2	2,518,943.9	1,209,468.7

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн сангийн харилцах	1,199,295.2	2,272,899.5	1,073,604.3
Арилжааны банк дахь харилцах	110,180.0	246,044.4	135,864.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	5,358.1	5,003.2	(354.9)
Дүн	1,315,191.8	2,523,947.1	1,208,755.3

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд 2,523,947.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь орон нутгийн ерөнхий орлогын дансны 2,157,958.4 мянган төгрөг, “Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын 129,686.1 мянган төгрөг, “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын 108,922.9 мянган төгрөг, дүүргийн хөрөнгө оруулалтын барьцаа 85,291.2 мянган төгрөг, ОНХС-ийн 33,953.1 мянган төгрөг, “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-ын 7,435.5 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангийн 700.0 мянган төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Жилийн эцсийн гүйлгээ хаагдсаны дараа татварын 5,003.2 мянган төгрөгийн орлого дүүргийн төрийн сангийн орлогын ерөнхий дансанд 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр он дамжиж орсон тул замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт:

- Бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан. /ЗДТГ 7,815.6 мянган төгрөг, “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ 5,000.0 мянган төгрөг, “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ 8,956.9 мянгантөгрөг/
- Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн урамшууллаас ХХОАТ суутгахгүйгээр олгосон. /Соёлын ордон 2,797.4 мянгантөгрөг/
- Албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур үзүүлэлтээр ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй олгосон. /”Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ 896.4 мянган төгрөг/
- Тэмцээн уралдааны шагналаас ХХОАТ суутгаагүй олгосон. /”Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ 262.9 мянган төгрөг/
- Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй. /ЖДҮДТ 1,419.7 мянгантөгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 65,612.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,514.6 мянган төгрөгөөр буюу 63.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	184.0	184.0
Дансны авлага /ТӨҮГ/	33,885.2	53,586.2	19,701.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	14.9	-	(14.9)
Байгууллагаас авах авлага	3,756.6	8,511.1	4,754.5
Хувь хүмүүсээс авах авлага	2,441.3	3,331.2	890.0
Дүн	40,097.9	65,612.5	25,514.6

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага данс 65,612.5 мянган төгрөгийн (“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-т 52,051.3 мянган төгрөг, ЗДТГ-т 7,156.9 мянган төгрөг, ИТХ-д 4,571.7 мянган төгрөг, “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-т 1,534.9 мянган төгрөг, ЖДҮДТ-д 187.7 мянган төгрөг, НТАГ-2025/009/НА-СТА-ТТЗ

“Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-т 110.0 мянган төгрөг)
үлдэгдэлтэй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,243.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,362.5 мянган төгрөгөөр буюу 47.7 хувийн буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,606.4	1,243.9	(1,362.5)
Дүн	2,606.4	1,243.9	(1,362.5)

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс 1,243.9 мянган төгрөгийн (“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-т 646.7 мянган төгрөг, “Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-т 597.3 мянган төгрөг) үлдэгдэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 2,348,678.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,422,725.8 мянган төгрөгөөр буюу 59.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	22,213.8	20,612.8	(1,601.0)
Аж ахуйн материал	288,616.6	258,967.9	(29,648.7)
Сэлбэг хэрэгсэл	3,572.3	33,436.6	29,864.4
Түлш, шатах тослох материал	2,386.3	3,517.2	1,131.0
Барилгын засварын материал	-	1,188.4	1,188.4
Бусад хангамжийн материал	500,456.7	250,289.3	(250,167.4)
Бусад нөөц	287,588.4	349,288.4	61,700.0
Дүн	1,104,834.0	917,300.6	(187,533.4)

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын данс нь худалдан авсан 1,745,603.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 875,248.5 мянган төгрөг, нийт 2,620,852.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 2,468,262.7 мянган төгрөг, акталсан болон байгууллага хооронд шилжүүлсэн 340,122.8 мянган төгрөг, нийт 2,808,385.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Бараа материал дансны 24.0 хувь нь “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-т, 21.2 хувь нь “Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-т, 20.1 хувь нь ЗДТГ-т, 15.3 хувь нь “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-т, 19.5 хувь нь бусад байгууллагуудад тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материал бэлтгэхдээ шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн дансанд бүртгээгүй байна. /ЗДТГ 7,825.0 мянган төгрөг, ИТХ2,800.0 мянган төгрөг/

- Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох тооцооны хуудас, тооцоо бодсон зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй байна. /"Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ 26,067.6 мянган төгрөг/

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 59,354.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,354.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	-	59,354.30	59,354.30
Дүн	-	59,354.30	59,354.30

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд дүүргийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа он дамжсан ажлыг бүртгэдэг байсныг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 5.4.4 дэх заалтыг үндэслэн бусад эргэлтийн хөрөнгө дансанд залруулан бүртгэсэн байна.

Энэхүү дансанд 59,354.3 мянган төгрөг тохижилт, засварын ажил бүртгэлтэй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,447,641.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,093,232.0 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	20,886,208.1	21,976,371.9	1,090,163.8
Барилга, байгууламж, орон сууц	12,162,797.1	12,342,045.3	179,248.3
Авто-тээврийн хэрэгсэл	2,683,559.1	2,920,748.2	237,189.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,300,218.3	3,460,430.4	160,212.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	292,694.0	272,933.7	(19,760.3)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,000.0	3,000.0	-
Бусад үндсэн хөрөнгө	2,420,032.8	2,953,307.4	533,274.6
Ном	23,906.8	23,906.8	-
Биет бус хөрөнгө	468,201.1	471,269.3	3,068.2
Програм хангамж	37,362.7	35,287.7	(2,075.0)
Бусад биет бус хөрөнгө	430,838.4	435,981.6	5,143.2
Дүн	21,354,409.2	22,447,641.2	1,093,232.0

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн худалдан авалтаар 65,455.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,657,968.5 мянган төгрөг, нийт 1,723,423.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 465,953.0 мянган төгрөг, байгууллага

хооронд шилжүүлсэн 164,238.8 мянган төгрөг, нийт 630,191.8 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна. Тайлант онд 1,678,406.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх тайлант жилүүдэд дахин үнэлсэн болон капиталжуулсан хөрөнгийн ашиглах жилийг программд өөрчлөөгүйгээс хөрөнгийн бүртгэлд хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн. /"Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ/
- Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулахдаа хөрөнгө орхигдуулж тоолсон. /ИТХ 1,845.5 мянган төгрөг/

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 241,178.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 119,798.7 мянган төгрөгөөр буюу 98.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	118,396.0	119,868.7	1,472.7
Ажилчидтай холбогдсон өглөг	4,412.2	8,933.4	4,521.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	14,020.2	14,020.2
Байгууллагад төлөх өглөг	85,119.4	45,751.0	(39,368.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	72.4	41.7	(30.7)
Татварын өглөг /ТӨҮГ/	26,336.8	33,758.0	7,421.2
Дансны өглөг /ТӨҮГ/	2,455.3	183.5	(2,271.7)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	17,180.9	17,180.9
Урьдчилж орсон орлого	2,984.2	1,399.0	(1,585.2)
Бусад урьдчилж орсон орлого	2,984.2	1,399.0	(1,585.2)
Урт хугацаат зээл	-	119,911.2	119,911.2
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	-	119,911.2	119,911.2
Дүн	121,380.2	241,178.8	119,798.7

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансанд “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-ын 165,582.7 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын 40,764.3 мянган төгрөг, ОНХС-ийн 19,006.8 мянган төгрөг, ЗДТГ-ын 8,965.1 мянган төгрөг, “Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-т 6,859.8 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнасан байна.

Урьдчилж орсон орлого дансанд “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ-ын айл өрхийн халаалт болон хэрэглээний халуун усны төлбөрийн илүү төлөлт 1,399.0 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд тусгасан өр төлбөрийн үлдэгдлийн тооцоог хийж баталгаажуулаагүй байна. /ЗДТГ 8,933.4 мянган төгрөг, дүүргийн хөрөнгө оруулалтын барьцаа 6,450.0 мянган төгрөг/

3.4.8 Засгийн газрын оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,956,164.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,007,861.8 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,115,911.0	2,114,849.2	(1,061.8)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,115,911.0	2,114,849.2	(1,061.8)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,095,543.5	3,604,082.8	508,539.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	356,188.9	356,188.9	-
Хуримтлагдсан үр дүн	7,783,852.1	8,225,132.6	441,280.5
Өмнөх үеийн үр дүн	6,629,552.8	7,792,374.6	1,162,821.8
Тайлант үеийн үр дүн	1,154,299.3	432,758.0	(721,541.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,596,807.5	3,655,911.2	59,103.8
Дүн	16,948,302.9	17,956,164.7	1,007,861.8

Эх сурвалж: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,956,164.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,007,861.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төрийн өмч, хуримтлагдсан үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дүүргийн ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд дүүргийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг нийт 9,883,139.3 мянган төгрөг, үүнээс нийслэлээс авах санхүүгийн дэмжлэг болон дүүргийн орлогын хэмжээг 9,863,839.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудын өөрийн орлогыг 19,300.0 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийслэлээс авах санхүүгийн дэмжлэгийг 5,949,618.4 мянган төгрөг, дүүргийн төсвийн татварын болон татварын бус орлогыг 1,769,024.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санг 564,413.4 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 117,766.1 мянган төгрөг, өөрийн орлогоос 21,800.0 мянган төгрөгөөр санхүүжихээр тус тус тооцон хүргүүлснийг Дүүргийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/28 тоот тогтоолоор 2024 оны төсвийг 8,422,621.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дүүргийн 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг Нийслэлээс авах санхүүгийн дэмжлэг 7,273,215.8 мянган төгрөг, орон нутгийн татварын орлого 1,769,024.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдлээс 42,766.1 мянган төгрөг, нэгдсэн ОНХС-ийн шилжүүлгээр 592,570.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 25,536.3 мянган төгрөг, оны эхний

үлдэгдлээс санхүүжүүлэхээр 1,044,840.2 мянган төгрөг, нийт эх үүсвэрийг 10,747,952.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийслэлээс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авсан бөгөөд ОНХС-ийн шилжүүлэг 96.0 хувь буюу 567,476.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 10. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			ЗӨРҮҮ	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,660,346.1	11,295,837.3	1,635,491.2	116.9
НИЙТ ОРЛОГО	1,794,560.3	3,455,145.1	1,660,584.8	192.5
УРСГАЛ ОРЛОГО	1,794,560.3	3,455,145.1	1,660,584.8	192.5
ТАТВАРЫН ОРЛОГО	1,467,024.0	2,838,022.1	1,370,998.1	193.5
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР	1,337,780.0	1,900,326.2	562,546.2	142.1
Хувь хүний албан татвар	1,337,780.0	1,900,326.2	562,546.2	142.1
Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах	1,153,300.0	1,419,213.7	265,913.7	123.1
Үйл ажиллагааны орлогын албан татвар	30,000.0	271,085.4	241,085.4	903.6
Шууд бус орлого	20,000.0	-	(20,000.0)	-
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар	32,000.0	44,361.7	12,361.7	138.6
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	40,000.0	64,653.6	24,653.6	161.6
Газрын төлбөр	62,480.0	101,011.8	38,531.8	161.7
Өмчийн албан татвар	46,324.0	200,692.7	154,368.7	433.2
Үл хөдлөх хөрөнгийн АТ	40,024.0	191,530.1	151,506.1	478.5
Малд ногдуулах албан татвар	5,300.0	8,078.6	2,778.6	152.4
Бууны албан татвар	1,000.0	1,084.0	84.0	108.4
Бусад татвар	82,920.0	119,880.3	36,960.3	144.6
Улсын тэмдэгтийн хураамж	10,000.0	31,170.6	21,170.6	311.7
Ус рашаан ашигласны төлбөр	5,000.0	7,798.7	2,798.7	156.0
Хог хаягдлын хураамж	67,920.0	80,911.0	12,991.0	119.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,000.0	588,213.6	286,213.6	194.8
Хүү, торгуулийн орлого	300,000.0	568,917.8	268,917.8	189.6
Ангилалдаагүй бусад орлого	2,000.0	19,295.8	17,295.8	964.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	25,536.3	28,909.4	3,373.1	113.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого	25,536.3	28,909.4	3,373.1	113.2
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	7,865,785.8	7,840,692.2	(25,093.6)	99.7
ОНТС-аас олгох шилжүүлэг	592,570.0	567,476.4	(25,093.6)	95.8
Санхүүгийн дэмжлэг	7,273,215.8	7,273,215.8	-	100.0

Орон нутгийн төсвийн орлогын татварын орлогын төлөвлөгөөг өссөн дүнгээр 1,467,024.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,838,022.1 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 193.5 хувьтай байна. Татварын бус орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 302,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 588,213.6 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 194.8 хувьтай байна. Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 25,536.3 мянган төгрөг гүйцэтгэлээр 28,909.4 мянган төгрөг бүрдүүлж, 113.2 хувьтай биелүүлсэн.

3.5.3 Дүүргийн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2 удаа тодотголоор 2,325,330.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 21 хөтөлбөрийн 18

арга хэмжээг нийслэлээс авах санхүүгийн дэмжлэг 7,273,215.8 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 25,536.3 мянган төгрөг, ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 42,766.1 мянган төгрөг, ОНХС-д олгох санхүүжилт 592,570.0 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 1,044,840.2 мянган төгрөг, татварын болон татварын бус орлогоос 1,769,024.0 мянган төгрөг, нийт 10,747,952.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 9,016,787.8 мянган төгрөг, ОНХС-ын өмнөх оны үлдэгдлээс 26,400.9 мянган төгрөг, ОНХС-д олгох 567,476.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 28,909.4 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,639,574.5 мянган төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 620,521.8 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 487,856.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				ЗӨРҮҮ	Гүйцэт- гэлийн хувь
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа /ИТХ/	822,749.9	796,609.7	26,140.2	96.8
2	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /ИТХ/	30,000.0	30,000.0	-	100.0
3	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглал, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх /ЗДТГ/	3,066,748.5	2,709,351.5	357,397.0	88.3
4	70403 Бүх шатны сонгууль зохион байгуулах	15,425.4	15,425.4	-	100.0
5	70418 Худалдан авах ажиллагаа	217,407.3	209,681.1	7,726.2	96.4
6	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	301,350.2	265,203.2	36,147.0	88.0
7	70501 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	640,636.1	599,177.3	41,458.8	93.5
8	70503 Орон нутгийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	1,011,712.2	565,314.9	446,397.3	55.9
9	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт	28,970.8	28,970.8	-	100.0
10	71702 Соёлын ордон	579,054.1	544,373.9	34,680.2	94.0
11	71508 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	621,475.9	621,475.9	-	100.0
12	71502 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээ	1,197,893.9	1,182,602.1	15,291.8	98.7
13	70901 Дулаан хангамжийн татаас	1,367,206.6	1,367,206.6	-	100.0
14	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	53,604.0	-	53,604.0	-
15	71701 Биеийн тамир спорт хороо	97,535.4	60,050.1	37,485.3	61.6
16	71801 Сургуулийн өмнөх боловсрол	120,616.3	103,233.6	17,382.7	85.6
17	71802 Ерөнхий боловсрол	195,999.7	195,852.0	147.7	99.9
18	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	9,392.0	529.2	8,862.8	5.6
19	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	298,230.0	278,573.1	19,656.9	93.4
20	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	65,944.1	65,944.1	-	100.0

21	72212 Хүүхэд хамгаалал	6,000.0	-	6,000.0	-
	ДҮН	10,747,952.4	9,639,574.5	1,108,377.9	89.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 200,275.6 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 120,000.0 мянган төгрөг, хандив, тусламжийн орлого 6,490.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,082.4 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01/1398 дугаар албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хариуцаж байсан хот нийтийн тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээний зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор Нийслэлийн ЗДТГ-аас 632,636.7 мянган төгрөг, нийт 972,484.7 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Нэмэлт санхүүжилтийн данснаас Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний зардалд 65.0 хувийг буюу 632,636.7 мянган төгрөг, ЗДТГ 19.3 хувийг буюу 187,959.9 мянган төгрөг, ИТХ 16.8 хувийг буюу 113,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6 .5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2024 оны А/21 тогтоолоор он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 12,335.4 мянган төгрөг, 2024 онд хэрэгжих 14 төсөл, арга хэмжээнд 999,376.8 мянган төгрөг, нийт 1,011,712.2 мянган төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хөрөнгө оруулалтын тухайн онд санхүүжих 15 төсөл, арга хэмжээг нийт 1,011,712.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээс 11 төсөл арга хэмжээнд 565,314.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, үүнээс гүйцэтгэгч байгууллагад 524,954.5 мянган төгрөг, техник хяналтын зардалд 6,526.2 мянган төгрөг, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд 3,263.1 мянган төгрөг, суутган тооцсон алдангид 215,0 мянган төгрөг, магадалшгүй ажлын зардалд 3,772.8 мянган төгрөг, барьцаа дансанд 26,583.2 мянган төгрөгийг тус тус гүйцэтгэлээр санхүүжүүлж, 446,397.4 мянган төгрөгийн ажлыг дараа онд гүйцэтгэхээр санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын 2024 оны “Дүүргийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” А/21 тогтоолоор он дамжин хэрэгжих 1 төсөл, арга хэмжээнд 42,766.1 мянган төгрөг, 2024 онд хэрэгжих 5 төсөл, арга хэмжээнд

597,870.0 5 мянган төгрөг, нийт 640,636.1 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр тухайн онд санхүүжих 1 төсөл, арга хэмжээнд нийт 42,766.1 мянган төгрөг, шинээр хэрэгжих 4 төсөл, арга хэмжээнд 582,238.4 мянган төгрөг, нийт 5 төсөл арга хэмжээнд 599,177.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч байгууллагад 554,006.4 мянган төгрөг, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд 2,474.4 мянган төгрөг олгож, барьцаа дансанд 27,929.0 мянган төгрөг, ТХЗ-д болон бусад зардалд 14,767.5 мянган төгрөгийг тус тус байршуулан оны эцэст үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Нийт барьцаа хөрөнгө: Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 989,535.8 мянган төгрөг байсан бөгөөд 1,216,649.1 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 382,094.3 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 1,824,090.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.7 .6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Нийслэлийн Багахангай дүүрэгт “Илч-Орд”, “Багахангай тохижилт”, “Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” гэсэн 3 ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагууд 2024 оны 06 сараас Дүүргийн Засаг даргатай салбарын чиглэлийн “Тохижилт, хог хаягдлын үйлчилгээний ажил гүйцэтгэх”, “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, ногоон байгууламжийн арчилгааны ажил гүйцэтгэх”, “Дулаан, хэрэглээний халуун ус үйлдвэрлэн, түгээх ажил гүйцэтгэх” гэрээг тус тус байгуулан, сар бүр салбар хариуцсан Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, хороод ажлыг дүгнэж, дүгнэсэн үнэлгээг үндэслэн Санхүү, төрийн хэлтсээс санхүүжилтийг олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн харъяа байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитор Э.Ундармаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/185 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үе шатанд 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 9,049,332.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 90,493.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус дүүргийн харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг хэтрүүлээгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 458,5106.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,414.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 17,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 438,096.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг төсвийн шууд захирагчдад өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ммм.зННепбапз.до[^].тп цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ нь 5 сая төгрөгөөс дээш зарлагын 46,654.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй зөрчлийг арилгах зөвлөмж, “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 551,998.7 мянган төгрөгийн орлогын 11 гүйлгээ, 191,614.3 мянган төгрөгийн зарлагын 18 гүйлгээг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг төсвийн захирагчдад хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн шууд захирагчид тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ нь илүү цагийн нэмэгдлийг бодохдоо дундаж цалин хөлсийг үндэслэн тооцоогүй 1,871.4 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, 2,025,376.9 мянган төгрөгийн 31 зөрчил илрүүлж, аудитын явцад залруулагдаагүй алдаа, зөрчлийг жилийн эцсийн аудитын дүнд нэгтгэн тайлагнасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 505,565.8 мянган төгрөгийн 23 зөрчил илэрснээс 1,405.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 315,082.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 189,078.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 19 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,405.0	1	1,405.0	100.0
Албан шаардлага	3	315,082.8	3	315,082.8	100.0
Зөвлөмж	19	189,078.0	19	189,078.0	100.0
Нийт дүн	23	505,565.8	23	505,565.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.
Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн урамшууллын асуудал;
- Нягтлан бодогч нарын чадавхыг сайжруулсан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, сан, зардал, 4 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэснээс 12 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 4 байгууллага /ИТХ, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба/, 3 сан, зардал /Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний зардал, ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/, 2 ОНӨТҮГ /Багахангай дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, Багахангай дүүргийн Соёлын ордон/, 3 ОНӨААТҮГ /"Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ, "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ, "Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ/-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	7	-
2	ОНӨААН		2	1	-
Дүн		2	2	8	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” /ЗДТГ, ИТХ, “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ/, “Хязгаарлалттай” /"Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 296,415.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 3,414.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн

акт тогтоож, 811,289.3 мянган төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 516,747.7 мянган төгрөгийн 29 зөвлөмж өгсөн.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 6,450.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Дүүргийн хөрөнгө оруулалтын барьцаа дансны өглөг 6,450.0 мянган төгрөгийг ААНБ-уудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, удалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа зөрчлийн тоо, мөнгөн дүн буурахгүй байгаа нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад анхаарч дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/													
№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		БУРУУ тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Төвлөрүүлэн захирагч												
1	Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал												
2	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	1	470.0			1	470.0	1	470.0				
3	Багахангай дүүргийн Дотоод аудитын алба												
4	Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	490.4			1	490.4	1	490.4				
5	Багахангай дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	2	16,931.8	1	6,301.8	1	10,630.0	2	16,931.8				
6	Багахангай дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан												
7	Багахангай дүүргийн Хөрөнгө оруулалт												
8	Багахангай дүүргийн Соёлын ордон	1	7,200.0			1	7,200.0	1	7,200.0				
9	Байгаль хамгаалах сан												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	5	25,092.2			5	25,092.2	5	25,092.2				
10	“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ	4	271,323.1			4	271,323.1	4	271,323.1				
11	“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ												
12	“Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ												
	ОНӨААН-ийн дүн	4	271,323.1			4	271,323.1	4	271,323.1				
	НИЙТ ДҮН	9	296,415.3			9	296,415.3	9	296,415.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/													
№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
	Төвлөрүүлэн захирагч	2	6,450.0			1	6,450.0	1	-				
1	Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	4,649.5					2	4,649.5				
2	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	4	24,574.0			2	16,749.0	2	7,825.0				
3	Багахангай дүүргийн Дотоод аудитын алба	-	-										
4	Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	-	-										
5	Багахангай дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	1	1,419.7			1	1,419.7						
6	Багахангай дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	-	-										
7	Багахангай дүүргийн Хөрөнгө оруулалт	-	-										
8	Багахангай дүүргийн Соёлын ордон	1	2,797.4					1	2,797.4				
9	Байгаль хамгаалах сан	-	-										
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	10	39,890.6	-	-	4	24,618.7	6	15,271.9				
10	“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ	6	36,183.8	1	262.9	1	26,067.6	4	9,853.3				
11	“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ	-	-										
12	“Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ	1	5,000.0					1	5,000.0				
	ОНӨААН-ийн дүн	7	41,183.8	1	262.9	1	26,067.6	5	14,853.3				
	НИЙТ ДҮН	17	81,074.4	1	262.9	5	50,686.3	11	30,125.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Төвлөрүүлэн захирагч	1	-					1	-
1	Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	120,508.4			1	17,000.0	3	103,508.4
2	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	2	255,015.1					2	255,015.1
3	Багахангай дүүргийн Дотоод аудитын алба	2	9,392.3					2	9,392.3
4	Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	3,686.0					2	3,686.0
5	Багахангай дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	2	7,712.0					2	7,712.0
6	Багахангай дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	-	-						
7	Багахангай дүүргийн Хөрөнгө оруулалт	-	-						
8	Багахангай дүүргийн Соёлын ордон	2	7,820.0					2	7,820.0
9	Байгаль хамгаалах сан	-	-						
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	15	404,133.8	-	-	1	17,000.0	14	387,133.8
10	“Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ	2	745,474.4			1	743,603.0	1	1,871.4
11	“Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ	2	1,464.5	1	1,464.5			1	-
12	“Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ	3	99,567.3	1	1,950.0			2	97,617.3
	ОНӨААН-ийн дүн	7	846,506.2	2	3,414.5	1	743,603.0	4	99,488.7
	НИЙТ ДҮН	22	1,250,640.0	2	3,414.5	2	760,603.0	18	486,622.5

